



APiP

Азия Пасифик Пропертис ХК

2015 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

№ 62

Улаанбаатар хот

"АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС" ХУВЬЦААТ КОМПАНИ
(цаашид **Компани гэх**)-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (цаашид ТУЗ гэх)-ИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн хараат бус гишүүн түр томилох тухай:

Компанийн тухай хуулийн 77.5, 77.6, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11.7, мөн 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн гишүүдийн эчнээ саналын хуудсаар ирүүлсэн саналуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ли Майкл Кашелл, ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Цэндсүрэн нар АРР ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр хүргүүлсэн тул Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг томилох үүднээс Нацагдорж овогтой Батжин болон Одончимэд овогтой Одгэрэл нарыг түр томилох саналыг баталсугай.
2. Дээрх асуудлаар санал өгөх эрх бүхий 9 гишүүнээс 7 гишүүний саналаар нийт 77,7 хувийн саналаар;
 - 2.1 Нацагдорж овогтой Батжин
 - 2.2 Одончимэд овогтой Одгэрэл нарыг АРР ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд түр томилсугай.
3. Энэхүү асуудлын талаар холбогдох газарт материал хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Булгантамир-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР АСТ
АЗИА ПАСИФИК
ПРОПЕРТИС

Ш.Ганбат

**“Азия Пасифик Пропертис” хувьцаат компанийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн Дарга**



APiP

Азия Пасифик Пропертис ХК

2015 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

№ 63

Улаанбаатар хот

"АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС" ХУВЬЦААТ КОМПАНИ
(цаашид **Компани гэх**)-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (цаашид **ТУЗ гэх**)-ИЙН **ТОГТООЛ**

Оазис барилгын төсөлтэй холбогдон байгуулсан гэрээг цуцлах болон шилжүүлэх тухай:

Компанийн тухай хуулийн 80.4 болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11.7, мөн 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн гишүүдийн эчнээ саналын хуудсаар ирүүлсэн саналуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн Оазис барилгын төсөлтэй холбогдон хийсэн “Монголиан Пропертис

1. Констракшн” ХХК болон “Монголиан Пропертис” ХХК-тай 2012 оны 02 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг цуцлах тухай Энэхүү төсөлтэй холбогдуулан хийсэн гэрээ нь хугацаа хэтрэлттэй болсон бөгөөд цаашид компанийн санхүүгийн байдал болон барилгын зөвшөөрөлтэй холбоотойгоор төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон тул гэрээний заалтуудыг 2 талууд харилцан тохиролцож торгууль алданги төлөлгүйгээр гэрээг цуцлах саналыг талууд оруулсан болно.

2. Мөн Компанийн Оазис барилгын төсөлтэй холбогдон хийсэн иргэн Нямцэрэн овогтой Болдбаатартай байгуулсан Урьдчилсан захиалгын гэрээг “Монголиан Пропертис Констракшн” ХХК-руу шилжүүлэх тухай асуудалд төслийг цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсонтой холбогдуулан иргэн Н.Болдбаатартай байгуулсан урьдчилсан захиалгын гэрээний урьдчилгаа төлбөр болох 10,000,000 төгрөгийн төлбөрийн хамт “Монголиан Пропертис Констракшн” ХХК-руу гэрээг шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал Д.Галбадрах-д үүрэг болгосугай.

Дээрх асуудлуудаар санал өгөх эрх бүхий 9 гишүүнээс 9 гишүүний саналаар нийт 100 хувийн саналаар:

1. Компанийн Оазис барилгын төсөлтэй холбогдон хийсэн “Монголиан Пропертис Констракшн” ХХК болон “Монголиан Пропертис” ХХК-тай 2012 оны 02 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг цуцлахыг зөвшөөрсүгэй;
2. Мөн Компанийн Оазис барилгын төсөлтэй холбогдон хийсэн иргэн Нямцэрэн овогтой Болдбаатартай байгуулсан Урьдчилсан захиалгын гэрээг “Монголиан Пропертис Констракшн” ХХК-руу шилжүүлэх тухай асуудалд төслийг цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсонтой холбогдуулан иргэн Н.Болдбаатартай байгуулсан урьдчилсан захиалгын гэрээний урьдчилгаа төлбөр болох

Утас: 99020866, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.apip-properties.com И-мэйл: info@apip-properties.com

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Олимпиин гудамж-16

Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот

10,000,000 төгрөгийн төлбөрийн хамт “Монголиан Пропертиз Констракшн” ХХК-руу гэрээг шилжүүлэхийг зөвшөөрсүгэй;

3. Дээрх 2 компанитай холбоотой асуудлаар хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал Дангаасүрэнгийн Галбадрахад үүрэг болгосугай.



Ш.Ганбат

“Азия Пасифик Пропертиз” хувьцаат компанийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн Дарга